



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 451

Улаанбаатар хот

**Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4, “Мэдээ, тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, нийт 101,676,573.01 (нэг зуун нэг сая зургаан зуун далан зургаан мянга таван зуун далан гурван төгрөг нэг мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал С.Наранцогтод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөллийг оролцуулан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийлгэн, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005544
23-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
 2023 оны 2 дугаар сарын 1-ны өдрийн
 45 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДАГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫГ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, марк, улсын дугаар, арал, хөдөлгүүрийн дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2022 оны 423 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
1	Форд ренжер, 04-86 УНӨ	2011/2014	39,356,594.26	39,356,594.26	-	12,000,000.00	6,000,000.00
2	Ландкрузер-71, 79-31 УНР	2011/2014	50,166,867.32	50,166,867.32	-	38,000,000.00	19,000,000.00
3	УАЗ Фургон, 37-14 УНР	2011/2014	12,153,111.43	12,153,111.43	-	7,500,000.00	3,750,000.00
	Нийт үнэ		101,676,573.01 (нэг зуун нэг сая зургаан зуун далан зургаан мянга таван зуун далан гурван төгрөг нэг мөнгө)	101,676,573.01 (нэг зуун нэг сая зургаан зуун далан зургаан мянга таван зуун далан гурван төгрөг нэг мөнгө)	-	57,500,000.00 (тавин долоон сая таван зуун мянга)	28,750,000.00 (хорин найман сая долоон зуун тавин мянга)